



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/213

Хэрлэн сум

**“Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” аянд
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорин гуравдугаар хуралдааны 2023 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасны дагуу “Хүүхдэд ээлтэй орон нутаг болно” зорилтын хүрээнд “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” аяныг орон нутагтаа зохион байгуулах зардалд 1,500,000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулсан тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
дугаар сарын 23-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

**“ДЭЭРЭЛХЭЛТ ДЭЛГЭРЭХ ЁСГҮЙ” МЭДЭЭЛЭЛ
СУРТАЛЧИЛГААНЫ АЯНЫ ТӨСӨВ**

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Хүүхдийг болзошгүй эрсдэлээс сэргийлэх нөлөөллийн 3х2м хэмжээтэй хулдаасан хэвлэл гаргаж, зам дагуух мэдээллийн самбарт байршуулах.	ш	2	110.000	220.000
2	Мэдээллийн том самбарт баннер тогтоох	ш	2	40.000	80.000
3	Тараах материал хэвлүүлж иргэдэд тараах	ш	400	1000	400.000
4	Аяны уриалга бүхий зураг барьж авхуулах хүрээ хийлгэж сурталчлах	ш	3	30.000	90.000
5	Иргэдийг уриалах хөөсөнцөр зураг авхуулах баннер хэвлүүлэх	ш	15	5000	75.000
7	Машины ард наадаг төрөл бүрийн стикер, түлхүүрийн оосор хийлгэж тараах	ш	200	1700	335.000
8	Аян уриалга үг бүхий зурагт постерийг гудамж талбайд байршуулах	ш	15	20.000	300.000
Нийт дүн					1.500,000